

2025 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ
/3-р улирлын байдлаар/

2025.09.26

1.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:Эрүүл мэндийн газарт 2025 оны 09-р сарын 20-ны байдлаар 43 иргэн өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд хариу хүргүүлсэн.Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

2.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн хэлбэр: Бичгээр-20, утсаар-23 тус тус ирүүлсэн байна.

3.Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /хувиар/

Нийт 43 өргөдөл, гомдолд

1. Эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-12 буюу 27,9 хувь,
2. Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой 7 буюу 16,2 хувь,
3. Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж байгаа асуудал 6 буюу 13,9 хувь,
4. Бусад -18 буюу 41,8 хувь байна. Хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэнд бичгээр болон утсаар хариу хүргүүлсэн.

4.Иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлүүлэхээр хандсан байгууллагууд:

- Эрүүл мэндийн газарт бичгээр –20,
- Засгийн газрын Олон нийттэй харилцах 1111 утсаар-8,
- Засаг даргын дэргэдэх төрийн үйлчилгээ мэдээллийн төв-70321111, ЭМГ-77112195 утсаар-15 тус тус ирүүлсэн байна.

Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай холбогдолтой иргэд та бүхний гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах Эрүүл мэндийн газрын утас-77112195 /сонголттой/, 99917149 дугаарууд тогтмол ажиллаж байна.

Эрүүл мэндийн газар